МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 08 сарын 27 өдөр Дугаар А/429 Мөрөн сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээг
хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.6, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, 94 дүгээр зүйлийн 94.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Мөрөн сумын 13-р баг "Цагаан-Уул хорооллын зүүн талд байршилтай нийтийн орон сууц барих газрын зориулалттай эзэмшүүлсэн 5 га (50000м^2) газрыг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гэрээнд заасан зориулалтын дагуу ашиглаагүй байх тул газар эзэмшигч хуулийн этгээд "Төрийн орон сууцны корпораци" ХХК (РД:5745535)-д эзэмшүүлсэн аймгийн Засаг даргын 2014 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн А/194 дүгээр захирамжийг хүчингүй болгосугай.

2.Уг захирамж гарсантай холбогдуулан "Төрийн орон сууцны корпораци" ХХК (РД:5745535)-д эзэмшүүлсэн 000434090 дугаартай газар эзэмших эрхийн гэрчилгээ, №1138 дугаар бхий гэрээг хүчингүй болгож газар эзэмшигчийн мэдээллийн сангаас хасалт хийхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг)-т даалгасугай.

3.Аймгийн Засаг даргын захирамжийг эс зөвшөөрвөл захирамжийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор аймгийн Засаг даргад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

4.Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг)-т үүрэг болгосугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Р.Машбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА П.ЛХАГВАЖАВ

Захирамж2024

6712011282